



БОЛОВСРОЛЫН
ХҮРЭЭЛЭН



THE WORLD BANK

IBRD • IDA | WORLD BANK GROUP


АГУУЛГА БОЛОН ХЭЛИЙГ ИНТЕГРАЦЧИЛАН СУРАЛЦАХУЙ – АХИС

*(Баян-Өлгий аймгийн хос хэлээр хичээл заадаг
ЕБС-ийн багш нар болон сургуулийн удирдлагад зориулав)*



АГУУЛГА БОЛОН ХЭЛИЙГ ИНТЕГРАЦЧИЛАН СУРАЛЦАХУЙ – АХИС

*(Баян-Өлгий аймгийн хос хэлээр хичээл заадаг
ЕБС-ийн багш нар болон сургуулийн удирдлагад зориулав)*



Энэхүү гарын авлагыг Дэлхийн банкны Бага боловсролын чанарын шинэчлэл төслийн дэмжлэгтэйгээр Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгээс хийсэн “Судлагдахуун ба хэлийг интеграцчилан суралцахуйг туршин нэвтрүүлэх” судалгааны хүрээнд боловсруулав.

Хэвлэлтэд зориулж хянан тохиолдуулсан:

У.Туяа (Ph.D), БСҮХ-ийн секторын эрхлэгч
Ж.Зүлмира MEdu, БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

Гарын авлагад орсон хос хэлт нэгж болон ээлжит хичээлийн төлөвлөлт боловсруулсан багш нар:

Р.Айнур, Өлгий сумын ЕБ-ын V сургууль, бага анги ангийн багш
И.Күлшат, Өлгий сумын ЕБ-ын V сургууль, бага анги ангийн багш
М.Маратхан, Өлгий сумын ЕБ-ын III сургууль, бага анги ангийн багш
Т.Еркегүл, Өлгий сумын ЕБ-ын III сургууль, бага анги ангийн багш
Х.Онаи, Өлгий сумын ЕБ-ын V сургууль, бага анги ангийн багш
А.Гэрэл, Өлгий сумын ЕБ-ын III сургууль, бага анги ангийн багш
М.Нуржамал, Өлгий сумын ЕБ-ын V сургууль, бага анги ангийн багш
О.Гүлсайра, Өлгий сумын ЕБ-ын V сургууль, бага анги ангийн багш
Б.Игилик, Өлгий сумын ЕБ-ын III сургууль, бага анги ангийн багш
Ш.Алтынтас, Өлгий сумын ЕБ-ын III сургууль, дүрслэх урлагийн багш
Ш.Роза, Өлгий сумын ЕБ-ын III сургууль, дүрслэх урлагийн багш
Х.Тилеуберди, Өлгий сумын ЕБ-ын V сургууль, дүрслэх урлагийн багш
Х.Молшылых, Өлгий сумын ЕБ-ын III сургууль, математикийн багш
З.Аузар, Өлгий сумын ЕБ-ын III сургууль, математикийн багш
Ж.Сайрангүл, Өлгий сумын ЕБ-ын V сургууль, математикийн багш
С.Дина, Өлгий сумын ЕБ-ын V сургууль, математикийн багш
М.Нургул, Өлгий сумын ЕБ-ын III сургууль, биологийн багш
С.Еркежан, Өлгий сумын ЕБ-ын III сургууль, биологийн багш
К.Баршагүл, Өлгий сумын ЕБ-ын V сургууль, биологийн багш
А.Гүлбаршын, Өлгий сумын ЕБ-ын V сургууль, биологийн багш
Ж.Габит, Өлгий сумын ЕБ-ын V сургууль, биеийн тамирын багш
Ж.Асан, Өлгий сумын ЕБ-ын V сургууль, биеийн тамирын багш
М.Мейрамбек, Өлгий сумын ЕБ-ын III сургууль, биеийн тамирын багш
Х.Аманбек, Өлгий сумын ЕБ-ын III сургууль, биеийн тамирын багш

Зөвлөн тусалсан сургалтын менежерүүдийн баг:

Н.Айнамкөз, Өлгий сумын ЕБ-ын III сургууль
Хахихат Гүлжан, Өлгий сумын ЕБ-ын V сургууль
Аниган Бейсхан, Өлгий сумын ЕБ-ын V сургууль
И.Хайрым, Өлгий сумын ЕБ-ын III сургууль
Б.Гүлжан, Өлгий сумын ЕБ-ын V сургууль
Х.Советхан, Өлгий сумын ЕБ-ын III сургууль

“ЭДМАРКЕТ” ХХК-д эхийг бэлдэж хэвлэв.

АГУУЛГА

ТАЛАРХАЛ

ЗАРИМ НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

НЭГ

АГУУЛГА БОЛОН ХЭЛИЙГ ИНТЕГРАЦЧИЛАН СУРАЛЦАХУЙ (АХИС)

- АХИС гэж юу вэ?
- АХИС сурагчдад ямар үр өгөөжтэй вэ?
- АХИС-г хэрэгжүүлэх багшийн үүрэг оролцоо

ХОЁР

АХИС БА СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТ, МОНИТОРИНГ

ГУРАВ

АХИС БА ХОС ХЭЛТ ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

- Хос хэлт нэгж хичээлийн төлөвлөлт
- Хос хэлт ээлжит хичээлийн төлөвлөлт

Талархал

Энэхүү зөвлөмжийг боловсруулахд үнэтэй хувь нэмэр оруулсан Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын III, Y сургуулийн нэр бүхий багш нар, сургалтын менежер, захиралд гүн талархал илэрхийлье. Ялангуяа, багш нар АХИС-н арга зүйгээр зохион байгуулах хос хэлт хичээлийн хөтөлбөр төлөвлөлт, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, хос хэлт хичээл заах, бие биенийхээ хичээлд сууж туршлага судлах, зөвөлгөө өгөх, хичээл төлөвлөлөө сайжруулах зэрэг олон ажил хийсэн юм. Энэ хэрээрээ ч багш нар маань ажлы байран дээрээ тасралтгүй хөгжсөн гэдэгт итгэж байна.

Мөн энэхүү АХИС арга зүйг судлах, суралцахад мэргэжил, арга зүйн болон санхүүгийн дэмжлэгийг эхнээс нь үзүүлж, хамтран ажилласан ЕАБХАБ-ын Үндэсний цөөнхийн асуудал эрхэлсэн дээд Комиссарын газар, Төв Азийн боловсролын хөтөлбөр, тэдгээрийн ажилтан, боловсролын зөвлөх, Монгол улс дахь НҮБ-ын Хүүхдийн сангийн хамт олон, ДБ-ны Бага боловсролын чанарын шинэчлэл төслийн хамт олонд талархал илэрхийлье.

БСҮХ нь 2018 оноос ЕАБХАБ-ын Үндэсний цөөнхийн асуудал эрхэлсэн дээд комиссарын газар болон Төв Азийн улс орнуудад хэрэгжиж буй “Олон хэлний боловсрол”-ын төсөлтэй хамтран ажиллаж эхэлсэн бөгөөд улмаар 2020 онд ЕАБХАБ-ын Үндэсний цөөнхийн асуудал эрхэлсэн дээд комиссар, Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайд нар хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зурсан юм. АХИС (CLIL) арга зүйг туршин нэвтрүүлэх, багш, мэргэжилтнүүдийг чадавхжуулахад энэхүү хамтын ажиллагаа ихээхэн ач холбогдолтой байсныг тэмдэглэж байна. Тухайлбал, 2018 оноос Баян-Өлгий аймгийн БШУГ болон ЕБС-ийн төлөөллүүд мөн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон үндэсний мэргэжлийн байгууллагын төлөөлүүд Төв Азийн Боловсролын бүсийн сургалтуудад тасралтгүй оролцож мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн нь туршилтын сургуулийн зорилтот судлагдахууны багш нар, оролцогч талуудыг мэдээллээр хангах, чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулахад чухал ач холбогдолтой байлаа.

Энэхүү гарын авлагыг Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын III, Y сургууль дээр 2021-2022 оны хичээлийн жилийн хоёр улирал хийсэн АХИС-г туршин нэвтрүүлэх туршилт судалгааны үр дүнд үндэслэн боловсруулсан. Уг туршин нэвтрүүлэх судалгааны хүрээнд зохион байгуулсан хос хэлт хичээлийн хөтөлбөр, төлөвлөлтийг боловсруулах, заах, сайжруулах, сургалтын толь бичиг боловсруулах зэрэг ажилд давхардсан тоогоор нийт 100 гаран багш сурган хүмүүжүүлэгч, мэргэжилтэн, сургуулийн удирдах ажилтан, 200 гаран сурагч оролцсон бөгөөд эдгээр хүмүүсийн хөдөлмөрийн үр дүн энэхүү гарын авлагад тусгагдсан болно.

Гарын авлагад орсон АХИС-н тухай ойлголт, АХИС-г нэвтрүүлэхэд багш нарын анхаарах асуудал болон менежмент, удирдлага зохион байгуулалтын талаарх зөвлөмж, багш нарын боловсруулсан хос хэлт хичээлийн төлөвлөлт зэрэг нь цаашид Баян-Өлгий аймгийн багш нарт туршлага болж сурагчдын сурлагын амжилтыг ахиулахад дэмжлэг болно гэдэгт итгэж байна.

БСҮХ-ИЙН ЗАХИРАЛ, ДОК М.ИТГЭЛ

ЗАРИМ НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Нэр томьёо		Тайлбар
Монгол	Англи	
Агуулга болон хэлийг интеграцилан суралцахуй	Content and Language Integrated Learning (CLIL)	Хэлний хичээлээс бусад судлагдахууны агуулгыг тухайн сурагчийн судалж буй зорилтот хэлээр заах сургалт, боловсролын үйл ажиллагаа
Эх хэл	Mother Tongue	Төрөлх хэл, өөрийн үндэсний хэл
Зорилтот хэл	Target language	Сурагчийн сурахыг зорьж буй, заавал сурсан байх хэл, тухайлбал, казах хүүхдүүдийн хувьд монгол хэл болно.
Хэл 1, Хэл 2.... (X1, X2)	Language 1, (L1) language 2 (L2)	X1- Эх хэл – судалгааны хүрээнд казах хэл X2- Монгол хэл – судалгааны хүрээнд сурагчийн заавал эзэмших хэрэгтэй монгол хэл
Төрийн хэл	State language	Төрийн бодлогоор статус тогтоосон, давамгайлах хэл 4.1.1.“төрийн албан ёсны хэл” гэж төрийн байгууллага, хуулийн этгээдийн аливаа үйл ажиллагаа явуулах, албан хэрэг хөтлөх орчин цагийн утга зохиолын монгол хэлийг; (МХтХ, 2015)
Гэрийн хэл	Home language	Сурагчийн гэртээ ярьдаг хэл, зарим сурагч гэртээ 2 хэлээр ярьдаг
Олон (хос) хэлт боловсрол	multilingual education bilingual education	<ul style="list-style-type: none"> - Олон хэлт боловсрол, хос хэлт боловсрол - Хоёр болон түүнээс олон хэлээр боловсрол эзэмших үйл явц

НЭГ. АГУУЛГА БОЛОН ХЭЛИЙГ ИНТЕГРАЦЧИЛАН СУРАЛЦАХУЙ (АХИС)

АХИС гэж юу вэ? АХИС сурагчдад ямар үр өгөөжтэй вэ?

CLIL (Content and Language Integrated Learning) – Судлагдахууны агуулгыг эх хэл болон зорилтот хэлтэй интеграцчилан суралцах, заах арга зүйг илэрхийлэх нэр томъёо бөгөөд судлагдахууны агуулгыг эзэмшихэд зорилтот хэл болон эх хэлийг зэрэг ашиглаж сургалт зохион байгуулах, эх хэлийг үнэлж, хоёр дахь хэлийг дэмжсэн арга хандлага юм. Энэхүү зөвлөмжид АХИС буюу агуулга болон хэлийг интеграцчилан суралцахуй гэж орчуулан хэрэглэсэн болно. Уг нэр томъёог 1994 онд Дэвид Марш судлагдахууны агуулгыг хоёрдогч, гуравдагч хэл дээр зааж сургах тохиолдлыг тодорхойлох үүднээс судалгааны эргэлтэд оруулсан байна.

Тус арга зүйг Европын орнуудад “4 C” (DoCoyle, 2008) үзэл санаанд үндэслэн авч үздэг байна.¹ Үүнд:

- Content – судлагдахууны агуулга: Судлагдахууны хүрээнд эзэмших мэдлэг, ур чадвар, чадамжийг дээшлүүлэх;
- Communication – харилцаа: Сургалтын үйл ажиллагаанд зорилтот хэлийг өргөн хэрэглэх;
- Cognition – танин мэдэхүй: Сэтгэх, таньж мэдэх чадварыг хөгжүүлэх;
- Culture – соёл: Хичээл хоорондын холбоо болон судлагдахуунаар дамжин олгогдох соёлын онцлогийг ойлгох.

АХИС-н зорилго нь судлагдахууны агуулгыг сурагчдад эзэмшүүлэх явцад тэдний хэлний мэдлэгийг хамт хөгжүүлэх явдал юм. Ингэснээр сурагчид тухайн судлагдахууны агуулга, нэр томъёог эх хэл болон монгол хэлээр сайтар ойлгож, тайлбарлаж чаддаг болно. АХИС нь дараах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэдэг. Үүнд:

- Сурагчдад судлагдахуунтай холбоотой шинэ мэдээлэл өгөх;
- Сурагчдын судлагдахуун, хэл хоёрыг зэрэг эзэмших боломжоор хангах;

- Сурагчдын хоёрдогч хэлээр ярих өөртөө итгэх итгэлийг дэмжих;
- Хичээлийн явцад сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилт, судлагдахууны агуулгыг эхний ээлжинд тавих;
- Хичээлийг хоёрдогч хэлний сургалтын төлөвлөгөөнд нийцүүлэн сурагчдын чадварт тохируулан төлөвлөх;
- Сурагчдын сэтгэх чадварыг бүх талаас нь хөгжүүлэх даалгавар ажиллуулах;
- Сурагчдад судлагдахуун агуулга, хэл хоёрыг зэрэг эзэмших явцад дэмжлэг үзүүлэх;

АХИС-г хичээлд ашиглахдаа:

- Хэлний хичээл биш, хэлний (монгол хэл, казах хэл) сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтыг чухалчилахгүй;
- Хичээлийг аль нэг хэлэнд орчуулах гэсэн үг биш;
- Судлагдахууны агуулгыг заахын зэрэгцээ, хэлний үндсэн 4 чадварыг (сонсох, унших, ярих, бичих) хөгжүүлнэ;
- Идэвхтэй сургалтын аргаар хичээлийг удирдана;
- Ихэвчлэн эх дээр (унших, сонсох, задлах) ажиллана.

АХИС нь үндэсний сургалтын хөтөлбөрийг хөнддөггүй бөгөөд харин түүнийг амжилттай хэрэгжүүлэхэд хэлний ялгаатай бүлгийн хүүхдүүдэд дэмжлэг болдог.

Тодорхой нэг судлагдахууныг АХИС-гаар заахын онцлог болон давуу тал нь:

- Сурагчид бага ангиасаа тодорхой судлагдахууны агуулга нэр томъёог монгол хэлээрээ эзэмшихийн хамт, эзэмшсэн чадвараа эх хэл дээрээ хөгжүүлэх боломжтой болно. Энэ нь монгол хэлийг зөвхөн монгол хэлний хичээлээр эзэмшүүлэхтэй харьцуулахад, сурагчдад олон шинэ боломж олгоно. Учир нь сурагчид хэл сурахын зэрэгцээ,

¹ <https://clilingmesoftly.wordpress.com/clil-models-3/the-4-cs-model-docoyle/>

- судлагдахууныг хамт судална. Өөрөөр хэлбэл, унших, сурах, сэтгэх чадварууд интеграцчилагдан гэсэн үг.
- Мөн АХИС нь багшид шинэ шаардлага тавина. Тус аргаар хичээл заадаг багш нь тухайн судлагдахууны мэргэжлийн багш, хэлний багш, анги удирдсан багш, туслах багшийн үүргийг нэг дор гүйцэтгэж чаддаг байх хэрэгтэй болно.
- Багшид тулгардаг томоохон бэрхшээл бол багшийн өөрийн мэргэжлийн ур чадвар маш сайн байхын зэрэгцээ 2 хэлний чадвар бас өндөр байх шаардлага юм. Энэхүү бэрхшээлийг даван туулах нэг арга зам нь судлагдахууны болон хэлний багш нар хамтран ажиллах явдал юм.

- Хэлний хичээл биш, хэлний (монгол хэл, казах хэл) хөтөлбөрийн зорилгыг чухалчилахгүй;
- Хичээлийг аль нэг хэлэнд бүхэлдээ орчуулах гэсэн үг биш;
- Судлагдахууныг заахын зэрэгцээ, үндсэн 4 чадварыг (сонсох, унших, ярих, бичих) төлөвшүүлэх ёстой;
- Идэвхтэй сургалтын аргуудыг хэрэглэнэ;

АХИС-н үнэлгээ нь интеграцийн хэлбэрээс шалтгаалж нэгдмэл, нарийн үйл явц юм. Рубрик нь АХИС-н нэгдсэн үнэлгээний шилдэг хэрэгсэл болно. Учир нь энэхүү бодит шалгуурууд нь суралцагчдаас хүлээгдэж буй үр дүнг урьдчилан төлөвлөх, харуулах боломжтой, стандарт шалгуурт тулгуурласан хэмжих өгөгдлүүдийн цогцолбор юм. Тэд АХИС үнэлгээнд маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Учир:

- Рубрик нь үнэлгээний хэд хэдэн төрлийг нэгтгэдэг: сурах-өөрийн үнэлгээ, сургах-багшийн үнэлгээ, суралцахуйн зорилгыг үнэлэх;
- Рубрик боловсруулахад ангийн сурагчдын ялгаатай байдлыг харгалзан үзнэ.
- Рубрик нь даалгаврын шалгуурыг тодорхойлно.
- Суралцагчдын мэдлэгийн түвшнийг тодорхойлохдоо хамгийн давуу тал

болон сайжруулах шаардлагатай талыг эргэх холбоогоор тусгана.

Багш нар рубрик боловсруулахад агуулгад хэрэглэгдэх үг хэллэг болон хэл зүйн цогцолбор, мөн сэдвийг тайлбарлах, хэлэлцэхэд хэрэглэгдэх үгсийг үнэлгээнд ашиглана. Мөн эргэх холбоог тодорхойлоход уг үг хэллэгийг хэрэглэж болно.

Харин суралцагчид нь рубрикийн ачаар юун дээр анхаарлаа хандуулж, ач холбогдол өгөх хэрэгтэй болохыг урьдчилан харах боломжтой. Түүний хамтаар асуудлыг тодруулах, шийдвэрлэхэд өөрийн болон бусдын ажлын үр дүнг үнэлэхэд рубрик их тус болно.

АХИС хичээлийг төлөвлөхөд үнэлгээний хэсгээ формат болон рубрик хэлбэрээр боловсруулна.²

АХИС-г хэрэгжүүлэх багшийн үүрэг оролцоо

Сургуулийн олон нийт хос хэлээр хичээллэх судлагдахуун болон Х1, Х2-ын харьцааг тогтоосны үндсэн дээр багш нар хамтран ажиллаж хос хэлт нэгж болон ээлжит хичээлийн хөтөлбөр, төлөвлөлтийг боловсруулж, хэрэглэгдэхүүнийг бэлтгэнэ.

² Xabier San Isidro, "CLIL CLASSROOM PRACTICES IN MULTILINGUAL EDUCATION IN

KAZAKHSTAN: GUIDELINES AND EXAMPLES", Astana, 2020, 11-20 тал

Гэртээ болон нийгмийн орчинд эх хэлээрээ (казах) харилцаж байгаад сургуульд орсон бага ангийн сурагчийн хувьд хоёр хэлийг хангалттай түвшинд хөгжүүлэхийн тулд орох, гарах мэдээлэл хоёр хэл дээр байх шаардлагатай. Энэ нөхцөл байдал сургалтын хөтөлбөрийн агуулгаас шалтгаалан өөрчлөгдөж болох ба сургалтын эхэн үед мэдээлэл нарийн төвөггүй хөнгөн хэлбэртэй байвал хэлийг сэлгэн шилжүүлж ашиглах боломж бүрдэнэ. Жишээ нь, сургалтын хөтөлбөрийн тухайн агуулга нэр томъёо ихтэй, үгс нь хийсвэр утгатай, өгүүлбэр нь нарийн бүтэцтэй байвал хэлийг сэлгэн шилжүүлж ашиглахад тохиромжгүй ба ялангуяа, энэ нь хоёр дахь хэлийг дөнгөж сурч эхэлж байгаа нөхцөлд бүр ч боломжгүй юм. Хоёр дахь хэлийг сайн эзэмшүүлэхийн тулд тухайн хичээлд ашиглаж буй эхийн агуулга, даалгаврыг хурдан ойлгуулах, дүрмийг тайлбарлах зорилгоор эх хэлийг ашиглана.

Багш сургалтын явцад хоёр хэлийг зэрэг ашиглах боломжийг ухаалгаар бодож боловсруулан, алсыг харж төлөвлөснөөр үйл явдалд дүн шинжилгээ хийж, хичээлийн “төрөл бүрийн”, “санаандгүй” аргуудыг ашиглан сэдэлжүүлж, мэдлэг бүтээлгэнэ.

АХИС нь багшид шинэ шаардлага, сорилтыг бий болгохын зэрэгцээ багш өөрөө хоёр дахь хэлийг сурах, сурагчаа танин мэдэх, багш нартай хамтран ажиллаж хөгжих боломжийг олгодог. Багш өөрийн мэргэжлийн ур чадвар маш сайн байхын зэрэгцээ шаардлагатай 2 хэлний чадвартай байх хэрэгтэй. Тийм учраас хичээл хоорондын холбоог маш сайн төлөвлөхийн хамт хэлний багш нартай хамтран ажиллах шаардлагатай болно.

Хос хэлт нэгж болон ээлжит хичээлийн хөтөлбөр, төлөвлөлтийг боловсруулахдаа дараах зүйлс анхаарч тусгана. Үүнд:

- Сурагчдыг судлагдахууны агуулга, хэл хоёрыг зэрэг эзэмших боломжоор хангах. Үүний тулд багш нар тухайн хичээлийн хүрээнд эзэмших ойлголтууд, үгийн нөөцийг төлөвлөдөг бөгөөд эдгээр ойлголтыг хэрхэн тайлбарлах зааварчилга, өгүүлбэрийн загвар зэргийг боловсруулж хэрэглэдэг. Мөн хичээлийн аль хэсэгт хэрхэн ашиглахаа төлөвлөдөг.
- Хичээлийн явцад судлагдахууны агуулгыг эхний ээлжинд тавих; АХИС нь тухайн судлагдахууны үндэсний сургалтын хөтөлбөрийн агуулгыг хөнддөггүй, суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэх гол зорилготой бөгөөд ингэхдээ эх хэл болон зорилтот хэлний академик мэдлэгийг дээшлүүлэхэд тусалдаг. Өөрөөр хэлбэл, сурагч судлагдахууны үндсэн ойлголтыг зорилтот хэлээрээ эзэмшихийн хамт, эзэмшсэн чадвараа эх хэл дээрээ хөгжүүлэх боломжтой болно. Энэ нь зорилтот хэлийг зөвхөн хэлний хичээлээр сурахтай харьцуулахад, сурагчдад олон шинэ боломж олгоно.
- Сурагчдын зорилтот хэлээр ярих өөртөө итгэх итгэлийг дэмжих; Үүний тулд багш нар сургалтын идэвхтэй арга зүйгээр дамжуулан ангийн уур амьсгалыг нээлттэй, аюулгүй, айдасгүй байхаар бүрдүүлж сурагч бүрт зорилтот хэлээр өөрийгөө илэрхийлэх боломжийг төлөвлөх хэрэгтэй.
- Хичээлийг сурагчдын чадварт тохируулан төлөвлөх;
- Сурагчдын сэтгэх чадварыг бүх талаас нь хөгжүүлэх даалгавар төлөвлөх;

Анги танхимд АХИС-н аргаар хичээл сургалтыг зохион байгуулахад дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Олон талт төвлөрөл; сурагчдын хэлний чадварыг судлагдахуун болон мэргэжлийн хичээлээр дэмжих;
- Судлагдахуун хоорондын интеграцийг хэрэгжүүлэх; Тухайлбал монгол хэлний хичээл дээр судалсан үйл үгийн хувирлыг судлагдахууныг агуулгыг эзэмшихдээ сурагчид ашиглана. Жишээ нь, түүхийн хичээл дээр голдуу монгол хэлний өнгөрсөн цагийн дүрмийг ашигладаг.
- Аюулгүй, баяжуулсан сургалтын орчиноор хангах; Тухайлбал,
 - сурагчид аль ч хэлээрээ айдасгүй, чөлөөтэй харилцах боломжийг бүрдүүлэх, монгол хэлээр ярихыг дэмжих,
 - багш сурагчийн хэлний алдааг байн байн сануулж, зэмлэхгүй, зөвхөн сурагчийн хэлснийг зөв дуудаж хэлээд, хэлний бүтцийг зөв ашиглах загварыг өгөх,

Багшийн үүрэг бол ангид гурван үйл явцыг (сургалтын үйл явц, баг доторх харилцааны хөгжлийн үйл явц, бие хүний хөгжлийн үйл явц) удирдан зохион байгуулах боломжийг бүрдүүлэхэд оршино.

- сурагчид шаардлагатай хэрэглэгдэхүүн болон толь бичиг бусад зүйл нь ангид аль болох хүрэлцээтэй, авч ашиглах боломжтой байх,...
- Сургалтын идэвхтэй арга зүйг ашиглах; Тухайлбал,
 - сурагчид ярих, бичих бүхий л боломжийг ашиглах, аман яриа болон бичгийн чадварыг хөгжүүлэх боломжтой байх,
 - хичээл дээр сурагчид багшаас их ярих (зарчим 80/20),
 - хэрэглэгдэхүүн, ТӨМ нь сурагчдын өдөр тутмын амьдралтай холбогдох, хэвлэл мэдээлэлд гарсан чухал, тулгамдсан материалууд болон бусад эх сурвалжийг өргөн ашиглах, бодит байдал болон эх сурвалжид ойр байх,
 - сургалтын хүрэх үр дүн болон түүнд амжилттай хүрэх арга замыг сурагчид өөрсдөө тодорхойлохыг дэмжих,
 - хичээл дээр хосын болон багийн ажлыг үр дүнтэй, оновчтой ашиглах боломжийг бүрдүүлэх,...
- Хамтран ажиллах; Тухайлбал,
 - судлагдахууны багш нар монгол хэлний болон эх хэлний багштай хамтран ажиллах, боломжтой бол хичээлийн төлөвлөлтийг хамтран боловсруулах,
 - сурагчдад эх хэл, соёлоо эзэмшихэд дэмжлэг үзүүлэх, монгол хэлийг хэрэглэх орчин бүрдүүлэх зорилгоор эцэг, эхийг сургалтын үйл явцад оролцуулах,
 - орон нутгийн боловсролын болон төр захиргааны мөн холбогдох байгууллагууд, ажил олгогчид, бусад зорилтот бүлгийг боловсролын үйл ажиллагаанд татан оролцуулах,...

Багш нар сургуулийн удирдлагатай хамтран сурагчдыг зорилтот хэлийг тээгчидтэй харилцаа үүсгэх боломжийг бүрдүүлэхэд анхаарна.

Сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгохдоо, сурагчдын насны онцлог болон хэлний мэдлэгийн түвшинг харгалзах хэрэгтэй. Мөн дууны болон дүрс бичлэг ашиглаж болно. Хамгийн гол нь сургалтын хэрэглэгдэхүүнийг хоёр зорилгоор сонгох учиртай бөгөөд энэ нь тухайн судлагдахууны агуулга эзэмшилт болон зорилтот хэлний түвшинг дэмжих юм. АХИС аргыг ашигладаг багш нар болон судлаачид сургах болон сурах явцад 2 хэлээрх сургалтын толь бичгийг ашиглахыг үр дүнтэй гэж үздэг. Сурагчдын өдөр тутам байнга хэрэглэх (идэвхтэй) үгсээс байнга хэрэглэдэггүй боловч, утгыг ойлгодог үгсийн (идэвхгүй) тоо их байдаг. Мөн хичээл дээр ашиглах шинэ үгсийг сонгохдоо тухайн судлагдахууны агуулга, сурагчийн хэлний түвшин, тухайн үгийн хэрэглээ зэргийг бодолцох ёстой. Тухайлбал хичээлд ашиглах ойлголт болон үгийг сонгохдоо

- Агуулгын хувьд өргөн, идэвхтэй (тухайн хичээл дээр хичнээн олон үг сурах боломжтойг тооцоолоход анхаарах (түвшин/чадвар))
- Давтамж (шинэ үг, холбоо үг хэр их (олон удаа) хэрэглэгддэг вэ гэдгийг анхаарах)
- Диапазон (үгсийн хэрэглэгдэх заг, хязгаарыг тогтоох)
- Танил эсэх (байнга хэрэглэгдэхгүй боловч, танил үг үү гэдгийг анхаарах)
- Ашиг тус (танилцсан мэдээллийн хэрэгцээ, шаардлага, зорилго юу болох) зэргийг харгалздаг байна.

АХИС-г зохион байгуулахад сургалтын хэрэглэгдэхүүн чухал ач холбогдолтой. Иймээс хос хэлт хичээлийн хөтөлбөр боловсруулах, төлөвлөхдөө сурагчдын ажиллах даалгавар, тарааж өгөх материал, сургалтын толь бичиг зэргийг хос хэлний зохистой харьцааг харгалзан боловсруулсан байх шаардлагатай.

АХИС-г туршин нэвтрүүлэх явцад багш нар бага боловсролын болон дунд ангийн зарим судлагдахууны сурах бичиг дээрх нэр томъёо, түгээмэл хэрэглэгддэг үгсийн монгол - казах, казах - монгол, монгол - тува, тува - монгол хэлээр орчуулсан толь бичиг гаргаж сургалтад хэрэглэсэн туршлага байна.

ДААЛГАВРАА ТӨЛӨВЛӨХ**Танин мэдэхүйн түвшний даалгаврыг боловсруулах**

Даалгаврууд нь танин мэдэхүйн бүх хүрээг хамарч байгаа эсэхийг шалгахын тулд багш нар тус загварыг ашиглана. Даалгавруудыг танин мэдэхүйн үүднээс ангилах:

	Нэрлэх	Ойлгох	Хэрэглэх	Задлан шинжлэх	Үнэлэх	Бүтээх
Даалгавар 1						
Даалгавар 2						
Даалгавар 3						
Даалгавар 4						
Даалгавар 5						
...						

Чиглүүлэх асуулт төлөвлөх

Багш хичээлийн үе шат бүрд зориулан чиглүүлэх асуултаа бэлдэнэ. Аливаа асуулт нь сонирхолтой, анхаарал татахуйц, эргэцүүлэн бодохуйц байх хэрэгтэй. Тийм асуулт нь суралцагчийн сонирхолыг төрүүлж, мэдэх, сурах гэсэн хүсэл, тэмүүлэлийг өдөөдөг болно. Суралцагчийн сонирхол нь өөрийн мэдлэгийн хүрээнд аливаа асуудлыг шийдэх, гол асуултад хариулж чадахад нь түлхэц болно. Асуулт нь хүнд боловч, ач холбогдолтой, сонирхолтой байх нь чухал. Тийм учраас багш бүр хичээлээ төлөвлөхөд суралцагчдын хэрэгцээ, сонирхолд нийцэх асуултыг боловсруулахад анхаарах хэрэгтэй. Асуудал дэвшүүлэхэд чиглэсэн асуултууд нь Блум таксономын танин мэдэхүйн түвшнийг дээшлүүлэх зорилготой байна.

Жишээ нь:

Хичээлийн үе шат	Чиглүүлэх асуулт
Оршил	Телевизийн мэдээгээр голын усанд хийсэн хог хаягдлаас болж 25 шувуу устасныг сонссон уу?
Судлах	Хог хаягдлыг багасгахын тулд дахин боловсруулах тогтолцоог яаж сайжруулж болох вэ?
Бататгах	Бусад улс орнуудын туршлагаас судалж үзлээ. Тэгвэл манай улсад юу хийж болох вэ?
Бүтээх	Өөрийн сургуульд хог хаягдлыг дахин боловсруулах тогтолцоог бий болговол яаж бол?

Хэлний 4 чадвараар даалгавар төлөвлөх


Багш амаар болон бичгээр өгөх янз бүрийн эхээ сонгож, сэдэв болон агуулга, бүлгийн (хүүрнэх, тайлбарлах, нотлох гэх мэт) хувьд зөв сонгож, оновчтой хэрэглэх нь зүйтэй. Хэлний 4 чадварыг хөгжүүлэх даалгаварт харьцааг нь хуваарилах байх хэрэгтэй. Үүнд дараах хүснэгтийг хэрэглэж болно.

	Сонсох	Унших	Ярих	Бичих
Даалгавар 1				
Даалгавар 2				
Даалгавар 3				
Даалгавар 4				
Даалгавар 5				
...				

ХОЁР. АХИС БА СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТ, МОНИТОРИНГ

Хос хэлний боловсролыг сургалтад нэвтрүүлэн хэрэгжүүлж буй улс орнуудын болон Баян-Өлгий аймгийн III, Y сургуулийн туршлагаас үзэхэд АХИС-г нэвтрүүлэхдээ дараах зүйлсэд анхаарлаа хандуулж чухаылчилдаг байна. Тэр нь:

- тухайн сургуулийн хос хэлт сургалтын бодлого, төлөвлөлт,
- эцэг эх, сурагч багш болон мэргэжилтнүүдийн үүрэг, оролцоо,
- сургалтын хэрэглэгдэхүүний боловсруулалт, хүрэлцээ,
- багшийн хөгжил, багшид үзүүлэх дэмжлэг туслалцаа,
- хос хэлт нэгж болон ээлжит хичээлийн хөтөлбөр зэрэг болно.



Эдгээрийг бүрэн хэрэгжүүлэхийг гол зорилго болгон ажиллахын хамт АХИС-н сургалтын орчныг бүрдүүлэхэд нөлөөлөх гол хүчин зүйл болох багшийн хөгжлийг хангах, тэднийг ажлын байранд нь хөгжүүлэх, хичээлийн төлөвлөлт хийх, нэгж болон ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах (толь бичиг, ажлын хуудас) зэрэг ажлыг нэн тэргүүнд тавьдаг байна. Тухайлбал, АХИС-г туршин нэвтрүүлсэн сургуулиудын үйл ажиллагаанаас харахад дараах хүрээнд ажилласан туршлага байна. Үүнд:

- Сургуулийн хос хэлт сургалтын бодлого/чиглэл-зорилго, зорилтыг тодорхойлох;
- Хос хэлт хичээл/сургалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх;
- Удирдлага, зохион байгуулалтаар хангах, дэмжлэг, үнэлгээ, мониторинг хийх зэргийг тодорхой тусгаж, төлөвлөсөн байх.

Сургуулийн хос хэлт сургалтын бодлого чиглэлийг тодорхойлох, талуудын оролцоо

Бага боловсролыг эх хэл дээр нь эзэмшүүлж буй ЕБС-ийн удирдлага нь багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагч зэрэг сургуулийн олон нийтийн оролцойтойгоор, орон нутгийн төр захиргаа, боловсролын удирдах болон мэргэжлийн байгууллагын дэмжлэгтэйгээр сургалтын хэлний бодлого, чиглэлээ боловсруулж хэрэгжүүлнэ. Энэхүү бодлого чиглэл нь талуудын ойлголцол, дэмжлэг, оролцоонд тулгуурласан тааламжтай, аюулгүй нөхцөл байдлыг бүрдүүлэхэд чиглэсэн байхад анхаарна. Ялангуяа, эцэг эхийн оролцоог хангах нь хүүхдийн сурах үйл явцад

ихээхэн ач тустайг анхаарч, тэдэнд зориулсан дэмжих болон хамтран ажиллах цогц арга хэмжээг төлөвлөж, үр дүнг тооцон ажиллана.

АХИС-г нэвтрүүлэх нь зөвхөн сургуулийн ажил биш, эцэг эх, асран хамгаалагчид, бусад талуудын оролцоо, хамтын ажиллагааны үр дүн байдаг. Туршин нэвтрүүлсэн сургуулиудын эцэг эхийн санал бодлоос үзэхэд тэдний 95 хувь нь уг аргыг сургалтад нэвтрүүлж чадвал “казах хүүхдүүдийн хувьд маш чухал болох”-ыг, “сургалтаа хос хэлээр явуулна гэдэг нь сайхан санаа болох”-ыг онцолсон байна. Тэдний хувьд хүүхдийн “эх хэлний боловсрол ч чухал, төрийн хэл ч чухал” бөгөөд хүүхэд нь “хоёр хэлээ сайн сурвал эцэг эхийн зорилго биелнэ” гэж үзжээ.

Баримт:

- Хүүхэд багаас нь 2 хэлийг хамт авч явах болсон нь зөв шийдэл байна. Манай хүүхдүүдийн хувьд хос хэл маш чухал. 1 хэл мэдэхээс 2 хэл мэдэх нь илүү гэдгийг хэн ч хүлээн зөвшөөрнө.
- Гол үгсийг 2 хэл дээр ойлгуулж өгч байгаа нь маш зөв байна.

(Эцэг эхийн ярилцлагаас)

Сургуулийн удирдлагын зүгээс АХИС-г нэвтрүүлэхдээ юуны түрүүнд дараах ажлыг үе шаттай зохион байгуулахыг зөвлөж байна. Үүнд:

- Багш нартай уулзаж, зорилгоо танилцуулах, тухайн суралцахуйн талаар сургалт (танилцуулах) зохион байгуулах
- Эцэг эхчүүдтэй уулзалт хийх (зөвшөөрөл авах),
- Сурагчдын тухайн судлагдахуунтай холбоотой монгол хэлний үгийн нөөцийг тандах, гарааны үнэлгээ, оношилгоо хийх,
- Хос хэлт нэгж болон ээлжит хичээлийн төлөвлөлт боловсруулах,
- Туршилт дадлагын хичээл зохион байгуулах, үүний үндсэн дээр төлөвлөгөлт, заах арга зүйг сайжруулах зэрэг болно.

Сургуулийн хос хэлт сургалтын төлөвлөлт, хэлний харьцаа

Сургуулийн хос хэлт сургалтын бодлого, чиглэлийг үндэслэн хос хэлний сургалтын төлөвлөлтийг боловсруулж, хэлний харьцааг тогтооно. Тухайлбал, тухайн сургуулийн хувьд аль ангиас, ямар судлагдахууныг хос хэлээр хичээллүүлэхийг тогтоох, судлагдахуун бүрийн Х1, Х2-ын харьцааг болон шаардлагатай санхүүжилт болон мэргэжлийн дэмжлэгийг тодорхойлж, түүнийг хаанаас, хэрхэн авахыг төлөвлөгөөндөө тодорхой тусгах шаардлагатай.

Х1, Х2-ын харьцааг тогтоосон байх нь багш хичээлийн төлөвлөлтөө хийхдээ хичээлийн аль хэсэгт, ямар хугацаагаар, аль хэлээр сурагчидтай харилцах, тэдэнд аль хэл дээр ямар зааварчилга өгөх зэргээ боловсруулахад чухал байдаг.

Сургуулийн хос хэлний төлөвлөлт боловсруулах, хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа (Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын III, Y сургууль дээр 2021-2022 оны хичээлийн жилийн хоёр улирал хийсэн туршилт судалгааны үр дүнд үндэслэн жишээ байдлаар харуулав.)

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа/ Үйл явц	Үр дүн
Сургуулийн ажлын хэсэг байгуулах - захирлын тушаалаар ажлын хэсэг томилох. Уг ажлын хэсэгт эцэг, эхийн болон мэргэжлийн байгууллагын төлөөлөл орсон байна	Захирлын тушаал
Сургуулийнхаа өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх - Багш, сурагчид, эцэг эхийг төлөөлөлтэй ярилцлага хийх, асуулга авах зэрэг аргаар үнэлнэ. Энэ нь гарааны үнэлгээ болно.	Үнэлгээний тайлан
Нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн сургуулийн хос хэлний сургалтын бодлого чиглэл, хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах - сургалтын хэлний талаар баримтлах бодлого чиглэл, мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмж, зааврыг ашиглана	Ажлын төлөвлөгөө
Бүгд нэгдсэн зорилго, чиглэлтэй болохын тулд сургуулийн олон нийтэд таниулга, сурталчилгаа хийх	Сурагчид, багш, эцэг эхтэй хийсэн уулзалт хэлэлцүүлэг

Хос хэлээр хичээлийг зохион байгуулах багш нарыг бэлтгэх, дэмжлэг үзүүлэх - АХИС-н ойлголт, үндсэн арга аргачлал - Хос хэлт нэгж болон ээлжилт хичээлийн төлөвлөлт хийх арга зүй - Сургалтын хэрэглэгдэхүүн	Судлагдахуун бүрийн хос хэлт нэгж болон ээлжит хичээлийн төлөвлөлт
Хос хэлний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх - Багш нар болон сурагчдын АХИС-г дэмжсэн зөвөлгөө, мэдээллээр хангах - Хамтран хичээл заах, хичээлийн хэлэлцүүлэг хийх - Сургалтын хэрэглэгдэхүүнийг хүрэлцээтэй ашиглахад зориулсан санхүүгийн болон техникийн дэмжлэг үзүүлэх - Явцын болон үр дүнгийн үнэлгээ хийж, дараагийн дэмжлэг, үйл ажиллагааг тодорхойлох	АХИС-н арга барилаар хичээллэсэн судлагдахуун, оролцсон багш сурагчид


Сургуулийн удирдлагын зүгээс хос хэлний сургалтын бодлого чиглэлээ тодорхойлох, АХИС-г нэвтрүүлэхийн өмнө сургуулийнхаа өнөөгийн нөхцөл байдлыг үнэлж, уг үнэлгээнийхээ дагуу тодорхой ажлыг төлөвлөх боломжтой. Ингэхдээ дараах асуулгыг ашиглах боломжтой бөгөөд энэхүү асуулгыг ЕАБХАБ-ын Төв Азийн орнуудын Олон хэлт боловсролын хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан шалгуурыг үндэслэн боловсруулсан болно.

Манай сургууль хос хэлний сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд бэлэн үү, бид юу хийх хэрэгтэй вэ?

Үндсэн шалгуур		Үнэлгээ/санал нийлэх эсэх		
		тийм	эргэлзэж байна	үгүй
1. Хос хэлний сургалтын хөтөлбөрийг (ХХСХ) хэрэгжүүлэх урам зориг хүсэл	Манай сургуулийн сурагчид нь угсаатны болон хэлний бүлгийн төлөөлөл мөн.			
	Бид ХХСХ-ийн зорилгоо тодорхой томъёолон дэвшүүлэхэд бэлэн байна.			
	Манай сургуулийн ХХСХ-ийн зорилго нь улс орныхоо боловсролын бодлоготой уялдсан байна.			
	Манай сургууль хос хэлээр хичээл зааж байсан туршлагатай.			
2. ХХСХ-ийн манлайлал ба төлөвлөлт	ХХСХ-ийг хэрэгжүүлэхийн тулд сургууль үүрэг, хариуцлага хүлээж чадна.			
	Багш нар ХХСХ-ийг хэрэгжүүлэхийн тулд мэдлэг, мэргэжлээ дээшлүүлж чадна.			
	ХХСХ-ийг хэрэгжүүлэхийн тулд сургуулийн сургалт-арга зүй (ЗАН) болон технологийн нөөцийг дайчлах, нэмэгдүүлэх боломжтой.			
	ХХСХ-ийг хэрэгжүүлэхдээ хөтөлбөрт хамрагдах бүх сурагчдад хэлний чадвар, бэлэн байдлын түвшин, сурлагын амжилт, нийгэм, жөндөр болон бусад шинж чанараас үл хамааран тэгш боломж олгох арга хэмжээ авна.			
3. Олон хэлний боловсрол дахь эцэг, эх, орон нутгийн иргэдийн дэмжлэг	ХХСХ-ийг хэрэгжүүлэх шийдвэрийг эцэг эх, багш нар, сурагчид зөвшөөрнө.			
	ХХСХ-ийг хэрэгжүүлэхэд эцэг эхчүүд нь туслагч байна.			
	Орон нутгийн засаг захиргаа, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж, тэдний нөөцийг татан оролцуулах боломжтой.			

АХИС-г нэвтрүүлэхэд хичээлийг зохион байгуулах хэлний харьцааг тогтоосон байх нь чухал. Хэлний харьцааг тогтоохдоо:

- Сурагчдын хэлний түвшин, үгийн нөөц,
- Эцэг, эхийн хүсэл,
- Тухайн хос хэлээр хичээл зохион байгуулах багш нарын оролцоо,
- Сургуулийн удирдлага болон орон нутгийн боловсролын байгууллагын саналыг харгалзан тэдний оролцоотойгоор тогтооно.



Дээрх хэлний жишиг харьцааг Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын III, Y сургууль дээр 2021-2022 оны хичээлийн жилийн хоёр улирал хийсэн туршилт судалгааны үр дүнд үндэслэн тогтоосон бөгөөд сургууль бүр өөрийн онцлог, бусад хүчин зүйлсийг харгалзан тогтоох боломжтой юм.

Удирдлага, зохион байгуулалт, дэмжлэг, үнэлгээ, мониторинг

Туршилтын сургуулиудын туршлагаас харахад АХИС арга зүйг нэвтрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах, АХИС-г хэрэгжүүлэх ангиуд болон судлагдахууны хуваарийг гаргах (2 сургуулийн багш нар бие биенийхээ хичээлд суух боломжоор хангах), багш нарын хичээлд сууж ажиглалт хийх, зөвлөн туслах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Мөн БСҮХ-ийн судлаачид сурагчдаас гарааны болон явцын, үр дүнгийн сорил авч, туршилтын үр дүнд дүн шинжилгээ хийжээ.

Багш, арга зүйч, судлаачдын тэмдэглэлийн хуудасны загвар – жишиг байдлаар

1. Ерөнхий тэмдэглэл

Хос хэлт хичээлийн сэдэв:	
Анги, бүлэг	
Сурагчийн тоо, үүнээс эмэгтэй	
X1, X2-ын харьцаа (төлөвлөснөөр)	
Сурагчдын X1-ийн мэдлэг чадвар	түлхүүр үг, нэр томъёог мэдэх байдал
Хугацаа	Нэгж хичээл Ээлжит хичээл

2. Хичээлийн явцын тэмдэглэл: Хичээлийн үйл явцыг дараах агуулгын хүрээнд хугацаа болон үйл ажиллагаа бүрээр тэмдэглэнэ.

X1, X2-ын харьцааг хангасан байдал	Хичээлийн аль хэсэгт X2-ийг ашигласан	
	Сурагч бүр X2-оор харилцах боломжтой эсэх	
	X1, X2-ын харьцааг оновчтой байсан эсэх	
	Сурагч бүрийг X1-ээр харилцахыг дэмжсэн эсэх	

Хичээлд ашигласан арга, аргачлал	Сурагч бүрийг Х2-оор харилцахыг дэмжсэн эсэх	
	АХИС-н үндсэн, идэвхтэй аргыг оновчтой ашигласан байдал, аргыг өөрчлөх шаардлагатай эсэх	
Хичээлийн хэрэглэгдэхүүн	Хэрэглэгдэхүүн нь Х1, Х2-ын уялдааг хангасан эсэх	
	Х2-ыг дэмжсэн эсэх	
	Оновчтой, хичээлийн зорилгыг дэмжсэн эсэх	
Сурагчдыг үнэлсэн байдал	Хүртээмжтэй байдал	
	Судлагдахууны агуулгын эзэмшилт, суралцахуйн зорилтын хэрэгжилтийг үнэлсэн байдал	
	Зорилтот хэлийг үнэлсэн байдал	

3. Энэ хичээлд өгөх Таны үнэлгээ (Тоо өсөх тутам Та тухайн хичээлийг сайнаар үнэлж байгааг илтгэнэ.)



4. Дүгнэлт, саналын тэмдэглэл: Хүснэгтийн мэдээлэл болон уг хичээлд өгсөн үнэлгээний үндэслэлийг ашиглана.

Агуулга	Дүгнэлт	Нэгж болон ээлжит хичээлийн төлөвлөлт, хэрэглэгдэхүүнийг сайжруулах санал, зөвлөмж
Х1, Х2-ын уялдааг хангасан байдал		
Хичээлд ашигласан арга, аргачлал		
Хичээлийн хэрэглэгдэхүүн		
Сурагчдыг үнэлсэн байдал		

Сурагчийн тэмдэглэлийн хуудасны загвар – жишиг байдлаар


1. Ерөнхий тэмдэглэл – жалпы белгілеу

Хос хэлт хичээлийн сэдэв: Қос тилдегі сабақ тақырыбы:	
Анги, бүлэг: Сыныбы, тобы:	
Хүйс: Жынысы:	

2. Үндсэн тэмдэглэл – нэгизги белгилеу

№		Таны тэмдэглэл - белгилеуиңиз
1.	Хичээл дээр Таны хийсэн хамгийн сонирхолтой ажил юу байв? Сабақта сиз орындаған ең қызықты жұмыс/әрекет қайсы?	
2.	Хичээл дээр Таны хийсэн хамгийн сонирхолгүй, уйтгартай ажил юу байв? Сабақта сиз орындаған ең қызықсыз, көңілсіз жұмыс/әрекет қайсы?	
3.	Та дараагийн хичээл дээр юуг хийх сонирхолтой байна вэ? Келесі сабақта не істегіңиз, қандай тапсырмалар орындағыңыз келеді?	
4.	Та энэ хичээл дээр ямар шинэ үг, нэр томьёог сурч авсан бэ? Сиз осы сабақта қандай жаңа сөздер, атаулар үйрендіңиз?	
5.	Та сурсан шинэ үг, нэр томьёогоо монгол хэлээр тайлбарлаж чаддаг болсон уу? Жишээ нь... Сиз өзіңиз үйренген жаңа сөздерді моңғолша түсіндіріп бере аласыз ба?	

3. Сиз үшін бұл сабақ қаншалықты маңызды болғанын бағалаңыз. (Сан артқан сайын сиз үшін сабақтың маңызды болғанын білдіреді)



ГУРАВ. АХИС БА ХОС ХЭЛТ НЭГЖ БОЛОН ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Сургуулийн хос хэлт сургалтын бодлого чиглэлийн хүрээнд хос хэлээр хичээллэх судлагдахуун болон Х1, Х2-ын харьцааг тогтоосны үндсэн дээр багш нар хос хэлт нэгж болон ээлжит хичээлийн хөтөлбөр, төлөвлөлтийг боловсруулна. Туршилтын сургуулийн багш нарын нэгж болон ээлжит хичээлийн төлөвлөлт боловсруулсан загварыг дор харуулав.

Нэгж хичээлийн төлөвлөлт (загвар)

Судлагдахуун:						
Судлах нэгж хичээл:						
Судлах улирал:						
№	Нэгж хичээлийн сэдэв	Судлах цаг	Суралцахуйн үр дүн		Хэлний харьцаа*	
			Судлагдахууны суралцахуйн зорилт	Хэлний зорилт	Х1	Х2
1.						

**Тайлбар оруулж болно.*

Нэгж	Ээлжит хичээл	Судлах цаг	Суралцахуйн үр дүн		Хэлний харьцаа	
			Судлагдахууны суралцахуйн зорилт	Хэлний	Х1	Х2

1	<i>Сурагчдын хэлний дүр зураг:</i>	
	- Гэрийн хэл, зорилтот хэлийг судалсан байдал	
2	- Сурагчдын зорилтот хэлний ерөнхий түвшин, үгийн нөөцийн талаар	
	<i>Хэлний зорилт</i>	
	- Унших	
	- Ярих	
	- Сонсох	
	- Бичих	

Нэгжийн үндсэн ойлголт, нэр томъёо, түлхүүр үг

№	Нэгж хичээлийн сэдэв	2 хэл дээр мэдэх, хэрэглэх ойлголт, нэр томъёо, түлхүүр үг	Тайлбар

Суралцахуйн зорилт (СҮД)-ын үнэлгээний шалгуур, гүйцэтгэлийн түвшин

Нэгж	Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн	СҮД-ийн шалгуур	СҮД-ийн шалгуурын гүйцэтгэлийн түвшин			
				1	2	3	4
<i>Үндсэн хэрэглэгдэхүүн:</i>							

Багш нар хос хэлт хичээлийн төлөвлөлтийг сайжруулааа дараах зүйлсийг анхаарсан байна. Үүнд:


1. Суралцахуйн үр дүн:
 - a) Хэлний зорилт-үр дүн: Зорилтот хэлний хувьд тодорхойлох;
 - b) Зорилтот монгол хэлний хүрэх үр дүнг хэмжигдэхүйц, суралцахуйн зорилтод тавьдаг шаардлагын (гүйцэтгэл, нөхцөл, шалгуур бүхий) дагуу аль болох гүйцэд тодорхойлох; Тухайлбал,
 - Унших-тухайн түлхүүр үгс орсон зорилтот монгол хэл дээрх эхийг (хэмжээг тавьж болно, жишээ нь: 4-5 өгүүлбэр бүхий эхийг, эсвэл сурах бичгийн ... талын эхийг гэх мэт);
 - Бичих – түлхүүр үгсийг өгүүлбэрт оруулах
 - Ярих – зөв дуудах г.м
 - c) Нэгж болон ээлжит хичээлийн суралцахуйн үр дүнг (зорилт) тодорхойлохдоо “судалж мэдэх, мэдлэг эзэмших” (биеийн тамир...), “хамаарлыг ойлгох” (5-мат...) зэрэг үйл үгийг ашиглахгүй байх;
1. Сурагчдын хэлний дүр төрх;
 - Тухайн нэгж, ээлжит хичээлийн хүрээнд сурагчид Х2 дээр ямар үгийн нөөцтэйг бичих – түлхүүр үгс болон нэр томъёоны хувьд
 - Мөн түлхүү ашиглагдах үйл үгийн цагийн хувьд – өнгөрсөн, одоо, ирээдүй, эсвэл тооны нэрийн тухайд, дээр, доор, их бага зэрэг...
2. Х1, Х2-ын харьцаа – бодитой байх, Х2-т чиглэх, туршилтын үр дүнд өөрчлөгдөх боломжийг тооцоолох;
 - Ялангуяа ээлжит хичээлийн төлөвлөлт дээр маш тодорхой төлөвлөх
 - Хичээлийн аль хэсгийг ямар хугацаагаар Х2 дээр, хэрхэн зохион байгуулах
3. Түлхүүр үгс, нэр томъёо;
 - Олон байх нь чухал биш.
 - Сурагчид тухайн түлхүүр үгс, нэр томъёог Х2 дээр ойлгодог, хэрэглэдэг болсноор тухайн судлагдахууны суралцахуйн зорилтыг амжилттай хэрэгжүүлж, сурлагт нь ахиц, дэвшил гарч амжилттай суралцсан байх учиртай.
4. Ээлжит хичээлийн төлөвлөлтийн хүснэгтэд Х1, Х2-ыг тэмдэглэх;

Туршлага:

Биологийн хичээлд суусан. 70/30-ийн харьцаатай сайн хичээл байсан. Хүүхдүүд монгол, казах хэлээр ярих үед багш зургаар дохио өгдөг нь сурагчдад сонирхолтой юм байна. Багшийн ур чадвар чухал болох нь харагдсан.

(Мэргэжилтний ярилцлагаас)

АХИС-н загварыг биологийн хичээлийн “Фотосинтез” сэдвийн жишээгээр харуулбал³:



³ “Эх хэл дээр суурилсан олон хэлний боловсрол: чанар, тогтвортой байдал” бүсийн сургалтын материал, Киргиз Улс, Ош хот, 2019 он.

Загварын дагуу багш нарын боловсруулсан нэгж болон ээлжит хичээлийн хөтөлбөрөөс жишээ болгон оруулав.

Нэгж хичээлийн төлөвлөлт

Бүлэг сэдэв: *Эерэг сөрөг тоо*

Анги: Дөрөв

Судлагдахуун: Математик

Сэдвийг заахад хуваарилагдах цаг: 6

Хичээл заах хэл:

Хэл₁ - казах хэл (сурагчдын эх хэл): 75%

Хэл₂ - монгол хэл (зорилтот хэл): 25%

Анхны (бага) боловсролын хэл: бүх сурагч бага боловсролын хөтөлбөрийг зөвхөн казах хэлээр эзэмшсэн.

Хэлний дүр зураг: Ангийн 38 сурагч бүгд гэртээ зөвхөн казах хэлээр ярьдаг, төрийн хэл болох монгол хэлийг 2-р ангиас судалж эхэлсэн байна.

Хичээлийн сэдэв: «Сөрөг тоог жиших»

Агуулгын хөтөлбөр: Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яамны зөвшөөрлөөр ерөнхий боловсролын 4 дүгээр ангийн математикийн хичээлийн Бага боловсролын хөтөлбөр.

Зорилго 1: Эерэг сөрөг тоог тоон шулуун дээр цэгээр тэмдэглэж, жиших, эрэмбэлэх чадвар дадал олгоно.

Зорилт:

- Сөрөг тоог унших, бичих, мэдлэг чадвараа бататгах;
- Сөрөг тоог тоон шулуун дээр тэмдэглэж, жиших, эрэмбэлэх;
- 1-2-оор нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох;

Зорилго 2. Математикийн хичээлийн агуулгыг эзэмшихийн хамт эх хэл дээр суурилж зорилтот хэлээ сурна.

Гол асуулт:

- Сөрөг тоо гэж юу вэ?
- Цаг агаарыг мэдэх нь бидний амьдралд ямар ач холбогдолтой вэ?
- Эерэг сөрөг тоог хэрхэн жишсэн байна вэ?
- Тоон шулуун дээрх эерэг тооны байрлал тоог жишихэд нөлөөлж байна уу?
- Термометрийн хоёр хуваарийн хоорондох бичигдээгүй хуваарийн утгыг хэрхэн унших талаар ярилцана.

Үндсэн ойлголтууд

- Термометрийн заалтыг уншиж, тоон шулуун дээр тэмдэглэнэ.
- Тоон шулуун дээр тэмдэглэсэн тоонуудын ялгааг олж харж, харьцуулна.
- Харьцуулсан тоог их багаар жишиж, сөрөг тоог танина.
- Хуваарьтай тоон шулуун дээр сөрөг тоог 1 эсвэл 2-оор нэмэгдүүлэн, хорогдуулан тоолно.
- Тэгийг тэмдэглэсэн хуваарьгүй тоон шулуун дээр тоонуудыг жишнэ.

Түлхүүр үг: Эерэг тоо, сөрөг тоо, тоон шулуун, хэм, цаг агаар, термометрийн заалт, их, бага, цаг агаарын мэдээ

Унших

- Термометрийн заалтыг унших;
- Термометрийн заалтыг 1-ээр нэмэгдүүлэн, хорогдуулан унших;

Сонсох

- Аман зааврыг ойлгох;
- Асуулт болон хариултыг хамт боловсруулах;
- Тусламж, мэдээлэл авах хүсэлтээ илэрхийлэх;

Ярих

- Математикийн шинжлэх ухааны хэллэгээр ярих;
- Нэмэлт тодруулга хүсэх тухай хүсэлтээ илэрхийлэх;
- Анги бүлгээрээ, багаараа, эсвэл хосоороо ярилцлага, хэлэлцүүлэгт оролцох;

Бичих

- Термометрийн заалтыг тоон шулуун дээр тэмдэглэх;

Нэр томьёо

Казах хэл	Монгол хэл
Термометр көрсеткіші	Термометрийн заалт
Сандарды салыстыру	Тоог жиших
Санмен өрнектеу	Тоогоор бичих
Төріс сан	Сөрөг тоо
Оң сан	Эерэг тоо
Ауа райы	Цаг агаар
Ауа райы болжамы	Цаг агаарын мэдээ
Градус	Хэм
Өлшеу	Хэмжих
Сантүзуі	Тоон шулуун
Арту	Өсөлт
Кему	Бууралт
0-дің оң жағы	0-ийн баруун тал
0-дің сол жағы	0-ийн зүүн тал

Агуулгын залгамж холбоо:

Өмнө судалсан агуулга		Одоо судлах агуулга	Цаашид судлах агуулга
<ul style="list-style-type: none"> • Эерэг сөрөг тоог таних; • Эерэг сөрөг тоог унших, бичих; 	•	<ul style="list-style-type: none"> • Сөрөг тоог тоон шулуун дээр тэмдэглэх; • Жиших; • Эрэмбэлэх; 	<ul style="list-style-type: none"> • Сөрөг тооны нийлбэр, ялгаврыг олох; • Тоон илэрхийлэл, тоон тэнцэтгэл бичүүлэх;

Орчин:

Материаллаг	Сэтгэл зүйн	Хэлний
<ul style="list-style-type: none"> • Анги танхим хичээл явуулахад тохилог таатай нөхцөлтэй байх; • Ном сурах бичиг, гарын авлага хангалттай байх; 	<ul style="list-style-type: none"> • Багш суралцагчийн харилцааны зөв, таатай орчинг бүрдүүлэх; • Багшийн бэлтгэсэн, үзүүлэн, тараах материал, тест нь тэдний нас сэтгэхүйн онцлогт тохирсон байх; 	<ul style="list-style-type: none"> • Нэгж хичээлээр эзэмших шинэ үгсийг илрүүлэн бэлтгэх;

Агуулга:

Хүлээгдэж буй үр дүн	Мэдлэг	Чадвар	Хэрэглээ	Үнэлгээ
4.1.6 Сөрөг тоог тоон шулуун дээр	Эерэг, сөрөг тоог жиших	Термометрийн хуваарийг унших, бичих, жиших	Тасалгааны агаар болон гадны агаарын температурыг мэдэх	Үнэлгээний шалгуур боловсруулж,

тэмдэглэх, жиших, эрэмбэлэх, 1-2-оор нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох аргыг ойлгоно.	Эерэг, сөрөг тоог жиших хүрээнд: - Сөрөг тоог тоон шулуун дээр тэмдэглэх, жиших, эрэмбэлэх	Термометрийн хоёр хуваарийн хоорондох бичэгдээгүй хуваарийн утгыг хэрхэн унших талаар ярилцах	Цаг агаарын байдлыг мэдэж, амьдрал ахуйд зөв ашиглаж сурах	түүнд нийцсэн жишиг даалгавар боловсруулж дүгнэнэ.
	- 1-2-оор нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох	Хуваарьтай тоон шулуун дээр сөрөг тоог 1 эсвэл 2-оор нэмэгдүүлэн хорогдуулан тоолох		
	- Жиших аргыг тайлбарлах	Тэгийг тэмдэглэсэн хуваарьгүй тоон шулуун дээр тоонуудыг жиших		

Судлагдахуун	Ур ухаан
- Эерэг сөрөг тоог унших, тэмдэглэх, жиших - 1-2-оор нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох	- Термометрийн заалтыг унших - Тоон шулуун дээр тэмдэглэх - Харьцуулах, - Тоон шулуун дээр нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох

Агуулгын задаргаа:

Нэгж сэдэв	Судлах цаг	Ээлжит хичээлийн сэдэв	цаг
Эерэг, сөрөг тоог жиших	6	Эерэг, сөрөг тоог унших, ялгах	1
		Тоон шулуун дээр тэмдэглэх	2
		Эерэг сөрөг тоог диаграммаар тэмдэглэх	2
		Сэдвийн шалгалт	1

АРГА: Асуудал дэвшүүлэн шийдвэрлэх, Бод, хамтар, хуваалц, сурагчид бие даан ажиллах

НЭГЖ ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ – 2

Судлагдахуун: Биеийн тамир

Анги: 6

Судлах улирал: Хос хэлт 6-р ангийн III улиралд судлах агуулга

Суралцагчдын хэлний дүр зураг:

- Гэрийн хэл: эх хэл дээр харилцдаг, зорилтот хэлийг 2-р ангиас судалж эхэлсэн.
- Сурагчдын хэлний ерөнхий түвшин: жагсаал зохион байгуулалтад хэрэглэгдэх цөөн хэдэн үгийг мэднэ. (номхон, 1-2-оор тоол г.м)

Судлах нэгж хичээл

№	Нэгж хичээлийн сэдэв	Судлах цаг	Суралцахуйн үр дүн		Хэлний харьцаа	
			Судлагдахууны суралцахуйн зорилт	Хэлний зорилт	X1	X2
1	Алхаа ба гүйлт	8 цаг	Гүйлт, харайлт, шидэлтийн тухай нэмэлт шинэ мэдлэгтэй болох	Гүйлт, харайлт, шидэлтийн мэргэжлийн нэр томъёоны үг хэллэгийг мэдэх	70	30
			Гүйж, харайж, шидэх техник сурч эзэмшинэ.	Гүйж, харайж, шидэх техниктэй холбоотой мэргэжлийн нэр томъёоны үг хэллэгийг мэдэх	70	30
			Авхаалж самбаа, хурд, хүч, уян хатан, тэсвэрийн чадвар хөгжинэ.	4 чадварыг эзэмшүүлэх	70	30

			ББХ төлөвшилтэй болно.	2 хэлний чадвараа хамт хөгжүүлэх	70	30
2	Хөл бөмбөг залах дамжуулах	10 цаг	Дасгалуудыг зөв гүйцэтгэх мэдлэгтэй болох	Нэр томьёоны үг хэллэгийг мэдэх, өгүүлбэрт оролцуулан ярих	70	30
			Хөл бөмбөг тоглох техник сурах	Нэр томьёоны үг хэллэгийг мэдэх, өгүүлбэрт оролцуулан ярих	70	30
			Авхаалж самбаа, уян хатан, тэсвэрийн чадвараа хөгжүүлнэ.	Нэр томьёоны үг хэллэгийг мэдэх, өгүүлбэрт оролцуулан ярих	70	30
			Зөв цэгцтэй хөдөлгөөнд сурч төлөвшинэ.	Нэр томьёоны үг хэллэгийг мэдэх, өгүүлбэрт оролцуулан ярих	70	30

Нэгжийн үндсэн нэр томьёо, түлхүүр үг

№	Нэгж хичээлийн сэдэв	2 хэл дээр мэдэх, хэрэглэх ойлголт, нэр томьёо, түлхүүр үг	Тайлбар
1	Алхаа ба гүйлт	Уртад хөл нугалж харайх техникийн бүтцийг 2 хэл дээр тайлбарлах	<ul style="list-style-type: none"> - Биет зургаар харуулах - Видео бичлэг үзүүлэх - Үзүүлэнгээр тайлбарлах - Багшийн тайлбарыг сонсох, ярилцах
		Үсрэх, харайх, гүйлтийн техник задлал гэх мэт үгийг 2 хэл дээр тайлбарлах	
		Халхалт, зөөлөн гүйлт, хурд гэх мэт үгийг 2 хэл дээр тайлбарлах	
2	Хөл бөмбөг залах дамжуулах	Бөмбөгийг өшиглөх, хөлийн улаар тогтоох зэрэг үгнүүдийг 2 хэл дээр тайлбарлах	<ul style="list-style-type: none"> - Биет зургаар харуулах - Видео бичлэг үзүүлэх - Үзүүлэнгээр тайлбарлах - Багшийн тайлбарыг сонсох, ярилцах
		Цувруулж ба сөөлжүүлж байрлуулсан тэмдэгтийг сүлжиж, бөмбөг залах техникийг 2 хэл дээр тайлбарлах	
		Заасан чиглэл руу буцаах болон хаалга руу өшиглөх аргуудыг хөл бөмбөг тоглохдоо хэрэглэхийг 2 хэл дээр тайлбарлах	

Нэгжийг ээлжит хичээлд хуваарилсан байдал

Нэгж	Ээлжит хичээл	Судлах цаг	Суралцахуйн үр дүн		Хэлний харьцаа	
			Агуулгын /суралцахуйн зорилт/	Хэлний /суралцахуйн зорилт/	X1	X2
Алхаа ба гүйлт	10-12м гүйлтээс уртад “хөл нугалж” харайх	1	Уртад харайх техникийн чадварыг аажмаар сайжруулах	Уртад хөл нугалж харайх техникийн бүтцийг 2 хэл дээр тайлбарлах	70	30
	Үсрэлт бүхий тоглоом	1	Уртын харайлтын амжилтаа ахиулах	Үсрэх, харайх гэх мэт үгнүүдийг 2 хэл дээр тайлбарлах	70	30
	Ойрын зайд босоо гараанаас 60м зайд дээд хурдаар гүйх	2	Гүйх чадвараа сайжруулах	Гүйлтийн техник задлалын дагуу гүйж сурах	70	30
	Буухиалан гүйж тоглохдоо гүйлтийн техник хэрэглэх	2	Буухиалан дамжуулж сурах	Гүйлтийн техникийн дарааллыг 2 хэл дээр тайлбарлах	70	30
	Халхалтыг давж гүйх техникээр 40см өндөр халхалтыг даван 20м гүйх	2	Зөөлөн гүйлтээс халхалтыг давах	Халхалт, зөөлөн гүйлт, хурд гэх мэт үгнүүдийг 2 хэл дээр тайлбарлах	70	30
Хөл бөмбөг залах	Өнхөрч ба ойж ирсэн бөмбөгийг хөлийн улаар тогтоох ба өшиглөх аргыг хэрэглэн үзүүлэх	2	Бөмбөгийг өшиглөх, хөлийн улаар тогтоох техник эзэмшүүлэх	Бөмбөгийг өшиглөх, хөлийн улаар тогтоох зэрэг үгнүүдийг 2 хэл дээр тайлбарлах	70	30

